



БАЯНХОНГОР АЙМАГ
БААЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/105

Баянсайр

“Эрүүл ажлын байр”, “Эрүүл мэндийг дээдлэгч өрх” шалгаруулах болзолт уралдааныг сумын хэмжээнд зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Эрүүл мэндийн сайдын А/472, А/780 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Эрүүл ажлын байр”, “Эрүүл мэндийг дээдлэгч өрх”, шалгаруулах болзолт уралдааныг 2022 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрүүдэд сумын хэмжээнд зохион байгуулсугай.

2. “Эрүүл ажлын байр”, “Эрүүл мэндийг дээдлэгч өрх”, шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, “Эрүүл ажлын байр шалгаруулах” шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар, “Эрүүл мэндийг дээдлэгч өрх” шалгаруулах шалгуур үзүүлэлтийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тус арга хэмжээнд зарцуулагдах хөрөнгийг байгууллагын арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Эрүүл мэндийн төвийн дарга (Д.Болормаа)-д зөвшөөрсүгэй.

4. Харъяалах нутаг дэвсгэрийн хүн ам, аж ахуйн нэгж, байгууллагыг болзолт уралдаанд идэвхтэй хамруулахыг баг, байгуулага, аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч, захирал, багийн эмч нарт, болзолт уралдаанд оролцох байгууллага, эрхийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн ажилтан (Л.Цэцгээ)-д, “Эрүүл ажлын байр”, “Эрүүл мэндийг дээдлэгч өрх”, шалгаруулах болзолт уралдааныг чанартай зохион байгуулж, шалгаруулалтын дүнг 2022 оны 11 дүгээр сарын 16-ны дотор танилцуулахыг Эрүүл мэндийн төвийн дарга (Д.Болормаа)-д тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Бямбаням)-д даалгасугай.

ДАРГА

СЭНХТӨР

642101485

Сумын Засаг даргын 2022 оны 09 дугаар
сарын 22-ны өдрийн 1105 дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт



"ЭРҮҮЛ АЖЛЫН БАЙР", "ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭЭДЛЭГЧ ОРХ"
ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Болормаа –Эрүүл мэндийн төвийн дарга

Гишүүд:

Б.Наранбаатар –Засаг даргын Тамгын газрын дарга

Э.Бат-Эрдэнэ –БОХ-ын улсын байцаагч

Б.Отгонжаргал - Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Б.Өсөхбаяр – Хэсгийн төлөөлөгч

Т.Бурмаа –Хими, биологийн багш

Н.Ариунжаргал- Соёлын төвийн бүжгийн багш

С.Цэдэв –Иргэний төлөөлөл


Ц.Эрдэнэхорол – Цэцэрлэгийн багш

Нарийн бичгийн дарга:

Л.Цэцгээ – Эрүүл мэндийн нийгмийн ажилтан

оОо

Сумын Засаг даргын 2020 оны 09 дугаар сарын 22-ны өдрийн 4105 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



“ЭРҮҮЛ АЖЛЫН БАЙР” ШАЛГАРУУЛАХ ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТ

Д/д	Үзүүлэлт	Шалгуур	Оноо (100)
1	2	3	4
Нэг. Эрүүл ажлын байрыг дэмжих бодлого			
1	1.1 Эрүүл ажлын байрыг дэмжих бодлогын бичиг баримттай байх	Эрүүл ажлын байрыг дэмжих хүний нөөцийн бодлого эсвэл заалт бүхий бол 1 оноо Эрүүл ажлын байрыг дэмжих хүний нөөцийн бодлого заалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй бол 1 оноо Байгууллагад хоол зүйч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, чийрэгжүүлэлтийн арга зүйч /тус бүр 0.5 оноо/ ажиллуулахаар тусгасан бол 2 оноо Хоол зүйч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, чийрэгжүүлэлтийн арга зүйч (тус бүр 0.5 оноо) ажиллуулдаг бол 2 оноо	6
		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүний төсөв, зардлыг баталж хэрэгжүүлдэг бол 3 оноо	3
		Ажлын байрны дарамт, шахалт, хүчирхийлэлтэй тэмцэх, жендерийн бодлоготой бол 1 оноо	1
		Онцгой байдлын үед авран хамгаалах, анхны тусламжийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөөтэй бол 1 оноо Дээрх төлөвлөгөөний дагуу ажиллагсдыг сургадаг бол 2 оноо Онцгой байдлын үед авран хамгаалах, анхны тусламжийн бэлэн байдлыг хангах гарын авлагатай бол 1 оноо	4
		Эрүүл ажлын байрыг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн хяналт, үнэлгээ хийдэг бол 1 оноо Дээрх үнэлгээнд эрүүл зан үйлийн үзүүлэлтийг оруулж тооцоолсон бол: 1. Архи, тамхинаас бүр мөсөн татгалзаж чадсан хүмүүсийн тоо 10 хувиас багагүй хувиар нэмэгдсэн бол 1 оноо 2. Таргалалт, илүүдэл жинтэй хүмүүсийн 2/3 нь биеийн жингийн индексээ хэвийн буюу 18.5-24.9-д хүргэсэн бол 1 оноо 3. Дасгал, хөдөлгөөн тогтмол хийдэг хүмүүсийн тоо 10 хувиас багагүй хувиар нэмэгдсэн бол 1 оноо 4. Эрүүл хоол, хүнс хэрэглэдэг хүмүүсийн тоо, 10 хувиас багагүй хувиар нэмэгдсэн бол 1 оноо	5
2	1.2 Эрүүл ажлын байрны үйл ажиллагаа, санхүүжилтийн төлөвлөгөөтэй байх	Эрүүл ажлын байрны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй бол 2 оноо Байгууллагын төсөвт эрүүл мэндийг дэмжих, эрүүл ажлын байрны үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжүүлэх санхүүжилтийг тусгасан бол 3 оноо	5
		Ажиллагсдаа нийгмийн даатгалд бүрэн хамруулсан бол 1 оноо Ажиллагсдаа эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулсан бол 1 оноо	2
Нийт оноо			26

Хоёр. Эрүүл ажлын байрыг дэмжих орчин			
3	2.1 Дасгал хөдөлгөөнийг хэвшүүлсэн байх	Ажлын байранд бүх ажиллагсад дасгал, хөдөлгөөнийг 6 ба түүнээс дээш сарын хугацаагаар хийж хэвшүүлсэн бол 3 оноо Ажлын байранд дасгал, хөдөлгөөн хийж хэвшүүлсэн туршлагаа сурталчилсан бол 2 оноо	5
		Байгууллагад дасгалын тоног төхөөрөмж 3-5 ба түүнээс дээш төрөлтэй бол 1 Байгууллагад дасгалын тоног төхөөрөмж, 6 ба түүнээс дээш төрөлтэй бол нэмэлт 1 оноо Дасгалын өрөөнд халуун, хүйтэн шүршүүр, хувцас солих өрөөтэй бол 1 оноо Хөхүүл эхийн хүүхдээ хөхүүлэх булан эсвэл өрөөтэй (хаалт, хүүхэд хуурайлах хэсэг, сандал, г.м) бол 1 оноо Ажиллагсад амрах, алжаал тайлах өрөөтэй бол 1 оноо	5
		Байгууллагын хамт олны бие бялдарын чийрэгжилтийн түвшин тогтоодог бол 1 оноо Байгууллагын хамт олны бие бялдарын чийрэгжилтийн түвшинг дээшлүүлэх үйл ажиллагаа зохион байгуулдаг бол 2 оноо	3
4	2.2 Эрүүл хооллолтыг хэвшүүлсэн байх	Байгууллагын хоолны газар ажиллагсад 9 сараас дээш хугацаагаар эрүүл хоолны сонголт бүхий цэсээр үйлчилсэн бол 2 оноо Байгууллагын хоолны газарт эрүүл хоолны цэсийг ажиллагсдад зориулан зохиосон бол 2 оноо Байгууллагын хоолны газарт эрүүл хоолны цэс, хоолны чанар, давс, өөх тосны хэмжээнд мэргэжлийн байгууллагын зөвлөгөө, үнэлгээ хийлгэдэг бол 2 оноо	6
		Байгууллагын ажиллагсдад эрүүл хоолны сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулдаг бол 2 оноо Эрүүл хоолоор үйлчилж хэвшсэн туршлагаа үндэсний болон орон нутгийн түвшинд сурталчилсан бол 2 оноо	4
		Хоолны газарт гар угаах, хатаах төхөөрөмжтэй бол 2 оноо, Шавж устгал, ариутгал тогтмол хийлгэдэг бол 2 оноо Хий, шатах бодисын хадгалалт шаардлага хангасан бол 2 оноо Ажлын байрны үндны эх үүсвэр чанарын шаардлага хангасан, усны чанарыг шинжилгээгээр баталгаажуулдаг бол 2 оноо	8
5	Архи тамхинаас татгалзсан ажлын байртай байх	Архи, тамхигүй ажлыг байр болох зорилт тавьж бодлого, төлөвлөгөөндөө тусгасан бол 1 оноо "Тамхи татах цэгийг" хуульд нийцсэн зайд байрлуулсан бол 1 оноо Бодлого, төлөвлөгөө, үйл ажиллагаандаа мэргэжлийн байгууллагын арга зүйн зөвлөгөө авч, үнэлгээ, хийлгэдэг бол 2 оноо	4
		Архи, тамхины хор уршгийг ойлгуулсан, архи, тамхинаас гарах зөвлөмжийг байгууллагын мэдээ, мэдээллийн самбар, цахим, хуудсаар тогтмол түгээдэг бол 3 оноо Архи, тамхины хортой хэрэглээг таниулсан сургалтыг зорилтот бүлгийн ажиллагсдад жилд 5-с доошгүй удаа зохион байгуулдаг бол 2 оноо Байгууллагын дарга, захирал, удирдлагын зөвлөл	11

		нь архи, тамхигүй ажлын байр болох үйл ажиллагаанд тогтмол дэмжлэг үзүүлдэг бол 1 оноо 100% Архи, тамхигүй ажлын байр болсон бол 5 оноо	
Нийт			46
Гурав. Эрүүл мэнд ба нийгмийн үйлчилгээ			
6	3.1 Эрүүл мэндийн үйлчилгээг хэвшүүлсэн байх	Бүх ажиллагсдыг жил бүр эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулж, хэвшүүлсэн бол 3 оноо /7 ба түүнээс дээш төрөл/ Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан туршлагаа үндэсний болон орон нутгийн түвшинд сурталчилсан бол 2 оноо Эрүүл мэндийн үзлэгийн төрлийг нэмэгдүүлсэн бол 1 оноо /нарийн мэргэжлийн үзлэг 3 ба түүнээс дээш/ Эрүүл мэндийн нарийн мэргэжлийн үзлэгийн үр дүнд ажиллагсдыг эмчлэн, эрүүлжүүлсэн бол 1 оноо	7
		Байгууллагын ажиллагсад болон үйлчлүүлэгчдээс ажлын байрны орчин, нөхцөлийн талаарх сэтгэл ханамжийн судалгаа тогтмол авдаг бол 2 оноо Байгууллагын ажиллагсад болон үйлчлүүлэгчдээс ажлын байрны орчин нөхцөлийн талаарх авсан сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг үйл ажиллагаандаа ашигладаг бол 1 оноо Ажиллагсдын ажлын бүтээмжийг дээшлүүлэх, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр судалгаа хийдэг, үр дүнг хэрэгжүүлдэг бол 2 оноо Ажиллагсдын ажлын бүтээмжийг дээшлүүлэх, эрүүл орчин бүрдүүлэх чиглэлээр стресс менежментийн арга хэмжээ, төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг бол 2 оноо Ажиллагсдын ажлын бүтээмжийг дээшлүүлэх, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр аялал, аян, өдөрлөг, зохион байгуулдаг бол 2 оноо	9
Нийт			16
Дөрөв. Эрүүл мэндийн зан үйл			
7	4.1 Эрүүл мэндийн зан үйлийн зэрэг өөрчлөлтийг дэмжих, урамшуулах, хамт олон болон олон нийтэд сурталчлах үйл ажиллагаа хэвшсэн байх	Байгууллагын хамт олны эрүүл мэндийн талаарх мэдлэг, хандлага, дадлын суурь судалгаатай бол 1 оноо Байгууллагын хамт олны эрүүл мэндийн талаарх мэдлэг, хандлага, дадлын судалгааг тогтмол хугацаанд зохион байгуулдаг бол 2 оноо Судалгааны үр дүнд суурилсан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлдэг бол 2 оноо	5
		Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг санаачлан зохион байгуулж, бусад байгууллагуудыг оролцуулдаг бол 2 оноо Бусад байгууллагуудын эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд оролцдог бол 1 оноо Ажлын байранд эрүүл мэндийн сурталчилгааны самбар тогтмол ажиллуулдаг бол 1 оноо Эрүүл мэндийг дэмжих сурталчилгааны булан, танхимтай, тогтмол ажиллуулдаг бол 3 оноо	7
Нийт оноо			12

Сумын Засаг даргын 2022 оны 09 дугаар сарын 12-ны өдрийн 2105 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт



"ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭЭДЛЭГЧ ӨРХ" ШАЛГАРУУЛАХ
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Д/д	Үзүүлэлт	Шалгуур	Оноо (50)
1	2	3	4
Нэг. Өрхийн эрүүл мэнд			
1	Өрхийн гишүүд эрүүл мэндийн нэг ба хоёрдугаар бүлэгт хамрагдсан байх	СӨЭМТ-ийн тодорхойлолт	Тийм-5 Үгүй-0
2	Өрхийн гишүүд эрүүл мэнддээ тогтмол хяналт тавьж, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт сайн дураараа жилд 1 удаа хамрагдсан байх	Нотлох баримт	Хамрагдсан-5 Хоёр жилд 1 удаа-1 Хамрагдаагүй-0
3	Өрхийн гишүүд архи, согтууруулах ундаа хэрэглэдэггүй байх	Архинаас гарсан байж болно. СӨЭМТ-ийн тодорхойлолт	Хэрэглэдэггүй-4 Хэрэглэдэг-0
4	Өрхийн гишүүд тамхи хэрэглэдэггүй байх	СӨЭМТ-ийн тодорхойлолт. Тамхинаас гарсан байж болно.	Хэрэглэдэггүй-4 Хэрэглэдэг-0
5	Өрхийн гишүүдийн биеийн жин хэвийн, дасгал хөдөлгөөнөөр хичээллэдэг байх	Биеийн тамирын секц, дугуйлан, клубт хамрагдсан нотлох баримт	Хэвийн жинтэй-5 Илүүдэл жинтэй-2 Таргалалттай-0
6	Зөв зохистой хооллолт, эрүүл хүнсний талаар мэдлэгтэй, өдөр тутмын амьдрал, ахуйдаа хэвшүүлсэн байх	Хоол судлалын мэргэжилтний үнэлгээ болон бусад нотлох баримт	Хангалттай-5 Дутуу-2 Хангалтгүй-0
7	Яаралтай тусламжийн эмийн сантай байх	Эмийн сан	Эмийн сантай-3 Эмийн сангүй-0
8	Эрүүл мэндээ сайжруулах, хамгаалах, зөв хооллолт, дасгал хөдөлгөөний ач холбогдлын талаарх мэдээллийг олон нийтийн сувгаар тогтмол мэдээлж хэвшсэн байх, бусдад зааж сургадаг байх.	Холбогдох нотлох баримт, байгууллагын тодорхойлолт	Хангалттай-5 Хангалтгүй-0
Нийт			36
Хоёр. Орчны эрүүл ахуйн ариун цэврийн талаар			
9	Гар угаалтуур, бие засах газар нь ариун цэврийн шаардлага хангасан байх, төрөл бүрийн ариутгалын уусмал ашигладаг байх	Гэр хороолол бол стандартын 00, бохир усны цооногтой байх	Хангалттай-5 Хангалтгүй-0
10	Амьдарч буй орчны ариун цэврийг сайжруулахад идэвх санаачилагтай оролцдог байх	Багийн Засаг даргын тодорхойлолт, бусад нотлох баримт	Хангалттай-5 Хангалтгүй-0
11	Эмнэлгийн анхан шатны тусламжийн талаар тодорхой мэдлэгтэй байх	Сум, өрхийн эмч шалгаж дүгнэлт гаргасан байх	Тийм-4 Үгүй-0
Нийт			14
Бүгд			50 оноо